

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ФИЛОСОФИ: СПИНОЗАГИЙН ФИЛОСОФИ ДАХЬ НАТУРА НАТУРАТА, НАТУРА НАТУРАНС ХЭМЭЭХ ОЙЛГОЛТУУДЫН ТУХАЙ

Б.Мөнхжавхлан (Доктор PhD)
Б. Дагзмаа (Доктор (PhD))
МУИС, ХУС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: натура натурата, натура натуранс, пантеизм, модус, бурхан, атрибут, субстанц, гүн экологи, экософи, хүрээлэн бүй орчны философи, экологи-би, өөрийгөө ухаарагчай

Төвч утга: Спинозагийн философи дахь Натура Натурата, Натура Натуранс хэмээх ойлголтууд нь хожуу үеийн хүрээлэн бүй орчны философиийн “Экологи-би” буюу “Өөрийгөө ухаарагчай” гэдэг ойлголтын үндэс болсон бөгөөд орчин үеийн гүн экологийн гол төлөөлөгч Арне Наэссийн “Өөрийгөө ухаарагчай” гэдэг нь хүн болон хүнээс бусад бүх зүйл өөрийн гэсэн дотоод үнэ цэнэтэй гэсэн үзэл санаанаас үүдээж энэ нь метафизикийн гэхээс илүүтэй ёс суртахууны агуулгатай гэж үзсэн болно.

* * * *

XVII зуун бол хүн төрөлхтний сэтгэлгээний түүхэнд онцгой хувь нэмэртэй ялангуяа философи мэдлэгийн ертөнцөд арга зүйн шинэ шинэ хандлагыг бий болгосон ў байсан юм. Энэ үеийн шилдэг рационалист Б.Спиноза Эзэн тэнгэрийн оршихуйн асуудалд уламжлалт Христийн теологийн агуулгын үүднээс бус харин онтологийн хүрээнд Эзэн тэнгэрийг байгалтай адилтган авч үзсэн нь тухайн зуун бол схоластицизмээс чөлөөлөгдөж буйн баталгаа болж байв. Энэ арга зүй нь байгальд хандах өвөрмөц хандлагыг рационал мэдлэгтэй холбох чухал сэжим болжээ. Цаашилбал XIX, XX зуунд марксист философи, хүрээлэн бүй орчны философи зэрэг нөлөө бүхий чиглэл, Делёз, Ницше, Сантаяна зэрэг философичдын үзэлд түүний философиийг натуралист, материалист үүднээс авч үзэх явдал дэлгэрсэн байдаг. Түүний философи үзлийн гол онцлог болох тус пантеизмийг хожмын хүрээлэн бүй орчны философиийн нэг чиглэл болох гүн экологи буюу Арне Наэссийн үзэлд хэрхэн онолын суурь болсныг энэ өгүүлэлд харуулах юм. Гүн экологийн¹ үндсэн санаа болох өөрийгөө ухаарагчай буюу экологи-би хэмээх ойлголт бол угтаа Спинозагийн үзлээс үүдэлтэй гэдгийг дараах байдлаар илэрхийлье.

1970-аад оноос философиийн мэдлэгийн нэгэн салбарт нийгмийн шаардлагаар орж ирсэн нэгэн чиглэл бол хүрээлэн бүй орчны философи юм. Энэ философиийн хувьд хүрээлэн бүй орчинд тулгамдаж бүй хүний хөндлөнгийн нөлөөтэй үйлдлээс улбаатай ус, хөрс, агаарын бохирдол, байгаль орчны доройтлын асуудал, байгальд хандаж бүй хүний хандлага анхаарлын төвд байх бөгөөд онолын хувьд төдийгүй нийгмийн амьдралд хүмүүсийн байгаль ертөнцөд хандах хандлагаа өөрчлөх, түүнд эрэгээр хандахыг уриалан сануулсан практик ач холбогдол бүхий хөдөлгөөн болж хувирсан байна.

¹ Гүн экологи үзэл: Наэссийн баримталдаг хүрээлэн бүй орчны философи экологийн зохицол ба тэнцвэрт байдлын тухай авч үздэг. Экософи нь агаарын бохирдол, нөөц, хүн ам гэсэн баримтууд төдий бус анхдагч үнэлэмжийг авч үздэг. Түүний бий болгосон гүн экологи хөдөлгөөн нь биоцентрист үзлийн үүднээс байгалийг өөрийнх нь төлөө буюу байгалийн бусад юмс, системийг өөрсдөө бие даасан байдлаар амьдрах, өөрийн үнэлэмжтэй талаас нь авч үзсэн үзэл билээ. Угтаа хүн ба хүний бус бүх зүйл дотоод үнэ цэнэтэй ажээ. Гүн экологи бол “илүү гүн” утгыг агуулдаг буюу хүний байгальтай харилцах харилцаанд холбогдох асуудлыг судалж байдаг. Энэ үзэл ёсоор, хүн амин чухал хэрэгцээгээ хангахаас өөрөөр байгалийн олон талт байдлыг бууруулах эрхгүй ажээ.

Энэ философи чиглэлд бие даасан хэд хэдэн үзэл баримтлал хамаардаг бөгөөд тус өгүүлэлд тэдгээрийн нэг болох экософиин тухай авч үзэхдээ ХХ зууны нэлөө бүхий хүрээлэн буй орчны философич Арнэ Наэсс, түүний үзэлд дээрх XVII зууны нэрт философич Спинозагийн үзэл нэлөөлснийг дор дурдсан эх сурвалжуудад түшиглэн судалж байна. Юуны түрүүнд Спинозагийн гол бүтээл болох Ёс зүй (1677)-д хэрхэн тэрээр философиин категориудаа боловсруулсныг, тэдгээр категориудаар Эзэн тэнгэрийг байгальтай адилтгасан санааг нотлон гаргасныг судлахын сацуу, хүрээлэн буй орчны философи, гүн экологийн талаар авч үздэг судлаачдын үзэл санаанд анализ хийж буй болно.

Гэхдээ энд Спинозагийн үзэл хүрээлэн буй орчны философи дахь Гүн экологийн тухай үзэлд хэд хэдэн агуулгаар холбогддог болохыг дурдах нь зүйтэй. Тухайлбал судлаач Алекс Гульерме “Метафизик нь Гүн экологийн суурь болох нь: Спинозагийн системийг шинжлэх нь”² өгүүлэлдээ хэдийгээр Гүн экологийг дэмжигч олон судлаачид өөрсдийн үзэл санааг батлахын тулд Спинозагийн үзлийг авч үздэг ч дараах санаанд тэд нэгддэг гэсэн байна. Тэдгээр нь 1.Дотоод үнэ цэнэ: Бүх зүйл өөрийн үнэ цэнэтэй бөгөөд, энэ үнэ цэнэ бол хүнд ашигтай байхаас хамааралгүй юм. 2.Биоцентрист эгалитари үзэл: Бүх зүйл, эс ч бай, нэг бүхэллэг ч бай, эсвэл Амазоны ай сав, эх дэлхий гэх мэт экосистем алин боловч тэнцүү үнэлэмжтэй. 3.Өөрийгөө ухаарагчай: бүх юмс өөрийгөө ухаарагыг эрмэлздэг. Гэвч тэрхүү ухаарал нь өөрийнхөө зорилгыг биелүүлэхийн тулд байдаг гэсэн үндсэн гурван санаанд тулгуурладаг гэж тэрээр бичжээ. Энэ үзэл нь улмаар хүний байгальд тулгах антропоцентрист үзлээс татгалзаж байгаль дэлхийд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн байна. Энэ өгүүллийн гол зорилго бол Гүн экологийн үндсэн санаа болох “өөрийгөө ухаарагчай” нь байгалийг эзэн тэнгэртэй адилтгах Спинозагийн үзэлд холбогдож байгаа гэдгийг өмнө дурдсан билээ.

Спиноза (1632-1677)-гийн үзлээр цорын ганц бодит орших зүйл бол “байгаль буюу Эзэн тэнгэр” юм. Тэрээр “бие ба оюун ухаан адил бөгөөд бугд нэгдмэл нэг эзэн тэнгэр гэж үзсэн билээ. Энэ пантеист, холистик үзэл норвегийн философич Арне Наэссиин үзэлд ихээхэн нэлөөлж, түүний үндэслэсэн гүн экологи үзэл нь Спинозагийн философиийг орчин үед үзэл санааны шинэ хандлага бий болгож, дахин дэлгэрэхэд хүргэжээ.

Спиноза өөрийн алдарт бүтээл болох “Ёс зүй”-гээ геометрийн аргаар бичсэн билээ. Тэрээр тодорхойлолт, аксиомуудаас үндэслэгээ гаргах замаар философи үзлээ илэрхийлсэн юм. Эзэн тэнгэрийг байгальтай, байгалийг Эзэн тэнгэртэй адилтгасанаар нь түүнийг пантеист гэдэг бөгөөд тэрээр Эзэн тэнгэрийн оршихуйг трансценденталь ахуйн хүрээнд тайлбарлахдаа “орон зай гэдэг нь Эзэн тэнгэрийн атрибут бөгөөд Эзэн тэнгэр бол ямар нэг тэлж байдаг зүйл”³ хэмээн тодорхойлжээ. Нөгөөтэйгүүр Спиноза Эзэн тэнгэрийг бүтээгч ахуй хэмээхээс илүүгээ оршин буй бүх зүйлд хамаатуулан авч үзсэн учир атеист хэмээн түүнийг нэрлэдэг ажээ.

Спинозагийн холист үзлийн утгыг тээсэн хоёр гол ойлголт бол Натура Натуранс, Натура Натурата (*Deus sive Natura*) бөгөөд энэ бол Эзэн тэнгэр буюу субстанц, байгалийн тухай тайлбар юм. Түүний философи дахь дедукцийн аргаар гаргаж авсан гурван тодорхойлолтыг дор дурдья. 1.Субстанц бол ойлголт нь ямар нэг юмны тухай ойлголтоос гарч ирдэгтүй, өөртөө байдаг, өөрөөрөө ойлгогддог тэр зүйл юм.(D3) 2.Атрибут гэдэг бол субстанц өөрийн мөн чанараа бүрдүүлэгч гэдгийг оюун ухаан хүртэж буйг хэлнэ.(D4) 3.Модус гэдэг нь субстанцийн өөрчлөлт буюу өөртөө оршигч, өөр ямар нэгэн зүйлээр дамжуулан ойлгогдохыг хэлнэ.(D5)⁴ Спинозагийн үзлээр цор ганц субстанц байх бөгөөд тэрбээр хязгааргүй, төгс, өөрөө өөрийнхөө шалтгаан болж, өөр юунаас ч хамааралгүй байдаг ажээ. Хэрэв Эзэн

² Alex Guilherme. *Metaphysics as a Basis for Deep Ecology: An Enquiry into Spinoza's System*. The Trumpeter. Volume 27, Number 3 (2011). Retrieved from <http://trumpeter.athabascau.ca/index.php/trumpet/article/view/1224>

³ Benedict Spinoza Ethics Demonstrated in Geometrical Order Jonathan Bennet 2017 p.24

⁴ Benedict Spinoza Ethics Demonstrated in Geometrical Order Jonathan Bennet 2017 p.1

тэнгэр байгалиас тусдаа гэж, мөн Эзэн тэнгэрээс өөр субстанцууд байдаг гэж үзвэл тэрээр хязгааргүй шинжтэй байж чадахгүй. Төгсгөлт буюу хязгаарлагдмал зүйлс Эзэн тэнгэрээс шалтгаацан оршиж эс чадах ажээ. Иймд тэд субстанц биш харин субстанцад оршин байна. Өөрөөр хэлбэл тэдгээр нь Эзэн тэнгэрийн илэрхийллүүд юм. “Ямар ч юм байсан, тэр нь Эзэн тэнгэрийн дотор орших бөгөөд, эзэн тэнгэрээс гадуур юу ч эс оршиж, танин мэдэхүйд өртөгдеж чадахгүй”⁵ гэжээ.

Тэрээр Эзэн тэнгэрийг тодорхойлохдоо дараах гаргалгааг хийсэн байна. Нэгэнт субстанц өөрөө хязгааргүй учир хязгааргүй атрибутуудыг агуулж байдаг. Энэхүү хязгааргүй атрибут бүхий субстанц бол эзэн тэнгэр гэж Спиноза тодорхойлсон. “Эзэн тэнгэр гэдэг бол абсолют хязгааргүй субстанц бөгөөд мөнхийн, хязгааргүйгээр илэрнэ”⁶ гэжээ. (D6) Эзэн тэнгэр хязгааргүй олон атрибуттай бөгөөд бид зөвхөн орон зай, сэтгэхүй гэсэн хоёр төрлийн атрибутиг мэдэрдэг. Сэтгэхүй хэмээх атрибутын дор бид хязгаарлагдмал шинжтэй оюун ухааныг оруулдаг бол орон зайн атрибутын дор хязгаарлагдмал биетүүдийг багтаан ойлгодог.

Спиноза “Ёс зүй” зохиолдоо атрибутиг “субстанцын мөн чанарыг бүрдүүлэгч...” хэмээснийг дээр үзсэн билээ. Тоо томшгүй олон атрибут байхын сацуу эдгээр нь субстанцийн хязгааргүй гэдгийн илэрхийлэл болдог байна. Орон зайн атрибут бол хөдөлгөөн ба тайван хоёр бөгөөд энэ нь субстанцийн анхдагч төлөв юм. Тодруулж хэлбэл хөдөлгөөн, тайван хоёр байгалийн өөрийнх нь шинж мөн. Физик ертөнц ч мөн бүхэлдээ хөдөлж буй систем юм. Бүхэл биет хэсгээс тогтох бөгөөд бодгалиудад эдгээр нь түгээмэл байна. Бүхлийн хувьд хэсгүүд нь нэмэгдэж, хорогдож байх боловч энэ нь тэдгээрт өөрчлөлт явагдаж буйг илтгэдэг. Тэрхүү өөрчлөлт нь хөдөлгөөн юм. Спинозагийн хувьд хөдөлгөөн бол байгалийн өөрийнх нь шинж төдийгүй анхдагч шинж юм. Бодгальд хэдий өөрчлөлт явагдах ч хөдөлгөөн тайван байдал хоёрын харьцаа хэвээр байдаг. Иймээс байгаль бол бодгалиуд буюу хэсгээс тогтдог, байгаль өөрөө нэгэн бүхэллэг, бодгаль систем болох нь тодорхой байна. Эндээс байгаль нь бодгалиудаас тогтдог гэдгийг харвал Гүн экологийн гол ойлголт болох “экологи-би” гэдэг ойлголт Спинозагийн энэ тайлбартай дүйх боломжтой юм. “Экологи-би” бол өөрийн биеэ, гэр бүл, хүн төрөлхтөн, үүгээр зогсохгүй биосфер, гариг, бүхэл орчлонг хамтатган хэлдэг “өөрийгөө ухаарагчай” гэдэг ойлголттой давхцдаг. Мөн “экологи-би”-гийн тухай санаа нь бодгаль ч гэсэн угтаа тэрхүү бүхэллэг байгалийн нэг хэсэг гэсэн утгыг илтгэж байна.

Цаашлаад Спиноза тайлбарлахдаа байгаль ийм тогтвортой тогтолцоо болохынхоо хувьд Эзэн тэнгэрийн мөнхийн модус болж байдаг гэсэн байна. Ингэснээрээ тэрээр байгалийн олон янз байдлыг үгүйсгээгүй. Харин ч олон зүйл юмст Эзэн тэнгэр өөрийн атрибутаараа бодгальд илэрч байдаг гэсэн ажээ.

Эндээс түүний *Natura Natura*, *Natura Natura* хэмээх ойлголт гарч ирдэг. Хязгааргүй Эзэн тэнгэр хэмээх ойлголт нь *Natura Natura*-д, харин байгаль гэдэг нь *Natura Natura*-д хамаарна. Байгаль⁷ бол онтологийн үүднээс Эзэн тэнгэрээс ангид зүйл биш, харин Эзэн тэнгэр хязгааргүй учир түүнд шингэмэл байдаг байна.

Сэтгэхүйн модусыг Спиноза “абсолют, хязгааргүй ойлгохуй” гэж нэрлэсэн байна. Энэ нь хайр, хүсэл хэмээх ойлголтоор хэрэгжиж байдаг. Эдгээр нь сэтгэхүйн модусууд буюу өөрчлөлтүүд ажээ. Сэтгэхүй бол оюун ухааны цогц юм. Ойлгохуй, бодохуй нь сэтгэхүйн гол модус мөн бөгөөд нэг нь нөгөөдөө байнга шилждэг, хязгааргүй шинжтэй. Энэ бол Эзэн тэнгэрийн хязгааргүй сэтгэхүй юм. Энэхүү хязгааргүй интеллект нь *Natura Natura*-д хамаарна. Хэрэв бид байгалийг *Natura Natura* буюу Эзэн тэнгэр гэдэг ойлголтоор харвал түүнийг ямар нэг өөрчлөлт, модус зэргээр тодорхойлох шаардлагагүй. Харин

⁵ Benedict Spinoza Ethics Demonstrated in Geometrical Order Jonathan Bennet 2017 p.7

⁶ Мөн тэнд

⁷ Константын бүтээлд “Эзэн тэнгэртэй адилтгагдаж буй энэхүү байгаль бол эмтирик утга бүхий байгаль биш, харин шилжимтгийн модусуудын ард байх хязгааргүй субстанц гэсэн өвөрмөц утгатай юм” гээж байгалийг тодотгосон байдаг. F.C.Copleston. A History of Philosophy. Vol 4. Doubleday, USA. 1993., P.232

Натура Натурата буюу байгаль гэдэг утгаар авч үзвэл, байгаль бол Эзэн тэнгэрийн илэрхийлэл, хязгааргүй олон модусын цогц билээ. Энд ямарваа трансцендент Эзэн тэнгэрийн тодорхой нэг юмыг бүтээсэн хөндлөнгийн оролцоог хайх шаардлагагүй, харин үргэлжилсэн нэг шалтгаацал л байх болно. Нөгөө талаас хязгаарлагдмал, нэгж шалтгаанууд л онтологи утгаараа байгалиас хамаарлтай тэр байгаль нь өөрөөсөө хамаарлтай, өөрөөсөө шалтгаацсан цор ганц субстанц буюу *Натура Натуранс* байх болно. Байгаль зайлшгүйгээр өөрийгөө илэрхийлдэг ба тэрээр бүх модус, өөрчлөлтийн имманент шалтгаан юм. Эзэн тэнгэр модусаас ангид байдаггүй. “Нэгж юмс бол эзэн тэнгэрийн атрибутуудын өөрчлөлтөөс өөр юу ч биш ба эзэн тэнгэрийн атрибут өөрийгөө илэрхийлж буй хэрэг” ажээ. Төгсгөлт шалтгаануудын хязгааргүй нэг хэлхээ нь байгалийг илэрхийлдэг бол бүхэллэг, хязгааргүй энэ хэлхээ байгаль оршдог учраас л байгаа ажээ. Иймд *Натура Натуранс* бол *Натура Натурата* бөгөөд аль талаас нь авч үзнэ гэдгээс хамаарч ялгаатай тайлбарлагддаг.

Байгаль бол өөрөө бүтээгч үйл явц, үйл ажиллагааны үр дүн буюу *Натура Натуранс* (энэ нь Эзэн тэнгэр мөн биз дээ) юм. Спиноза үзэхдээ Эзэн тэнгэр байгалийн хуулиудаараа дамжуулан ертөнцийг чиглүүлж байдаг гэсэн. Түүнийхээр материаллаг ертөнц дэх бүх юмс зайлшгүйн хуулиар хэрэгждэг ажээ. Тэрээр байгальд болж буй бүх юмсын дотоод шалтгаан, имманент зарчим учир байгалиас өөр зүйл байж болохгүй. Энэ санаа нь эзэн тэнгэрийг ёс суртахууны чиглүүлэгч, нүглийн тухай ойлголт, чөлөөт хүсэл, сайн ба муугийн дэнслэгч гэсэн санаанаас чөлөөлдөг. Үүний оронд ертөнц бол оюун ухаанаар чиглүүлэгдсэн хэмээн ойлгох ёстой ажээ. Байгаль дээр санамсаргүй зүйл гэж огт үгүй бөгөөд оршин буй бүх юмс зайлшгүйн хуулин дор хэрэгжиж байдаг. Спиноза газар хөдлөлт, өвчин эмгэг гэх мэт байгалийн хатуу ширүүн үзэгдлийг гай зовлон, нүгэл хэмээн үзэх нь хүн тэдгээр үзэгдлийг хэрхэн авч үзэж буйгаас хамаарч байгаа, улмаар тус үзэгдлүүдийг байгалийн хуулийн хэрэгжилтийн нэг хэсэг гэж үзсэн нь түүний тайлбар нэлээд метафизик агуулгатайг харуулж байна. Эндээс үүдэж түүний философи үзэл дэх хүн бол чөлөөт хүсэл бүхий биш харин шалтгаацлын нэг хэсэг гэдгийг эндээс харж болж байна.

Субстанцад бодгаль шинж байхгүй бөгөөд хэрэв бодгаль шинж байдаг гэж үзвэл тэр нь ямар нэг атрибутаар илэрч, атрибут нь түүний хязгаарлагдмал болохын илрэл болох ажээ. Иймд субстанцад хүсэл, оюун ухаан гэх бодгальд байх ямарваа шинж байхгүй юм. Субстанцийн хувьд шалтгаан, үрийн ялгаа байхгүй, үүнээс гадуур юу ч оршихгүй ажээ. Ямарваа объект өөрийн үүсэл, амьдрал, төгсгөлтэй бөгөөд энэ нь бүгд субстанцад оршдог учир ертөнц бүхэлдээ субстанцийн янз бүрийн модусын цогц юм. Субстанц өөрийн уг чанараараа модусаасаа өмнө оршин байна. Түүний үзлийг Альфред Вебер “Спинозагийн философи” өгүүлэлдээ “бодит байдал бол субстанц бөгөөд харин модус бол бодгаль, хөдөлгөөн, үйл явц, бие, сүнс бүгд бөгөөд бодит оршихуй үгүй *Натура Натурата* ажээ”⁸ гэж дүгнэн бичсэн байна.

Спинозагийн пантеизм Арне Наэссийн үзэлд онолын суурь болохыг олон судлаачид авч үзсэн байдаг бөгөөд энэхүү өгүүлэлд тийм байр суурийг дэмжиж буйг илтгэж байгаа ч гэсэн Арне Наэссийн үзэл дэх “Өөрийгөө ухаарагчай” гэдэг бол “Экологи Би” гэдгээ ухамсарлаж, биосферт өөрийгөө ойртуулан түүнийг хамгаалах хандлагыг илэрхийлдэг нь түүний үзэл баримтлал хүн болон хүнээс бусад бүх зүйл өөрийн гэсэн дотоод үнэ цэнэтэй гэсэн үзэл санаанаас үүдэж энэ бол метафизикийн гэхээс илүүтэй ёс суртахууны агуулгатай гэж үзэж болно. Арне Наэссийн үзэл ёсоор хүн байгалийг ямарваа зүйлийг өөрийн нэг хэсэг гэж үзэн “өөрийгөө хамгаалж буй” хэрэг ажээ. Энэхүү “өөрийн төлөө” гэсэн ойлголт бол бидний хамгийн “гүн”, ямарваа зүйлийг хийх сонирхол шалтгаан юм”⁹. Угтаа “өөрийгөө ухаарагчай” гэдэг нь бидний ахуйн бололцоогоо хэрэгжүүлж байгаа гэсэн метафизик агуулгатай байна.

⁸ Retrieved from: http://www.sophia-project.org/uploads/1/3/9/5/13955288/weber_spinoza.pdf

⁹ Retrieved from https://www.researchgate.net/publication/305702378_Environmental_Philosophy

Эндээс дүгнэн үзэхэд:

1. Спинозагийн философи дахь *Natura Naturata*, *Natura Naturans* хэмээх ойлголтууд нь хожмын хүрээлэн буй орчны философиийн “Экологи-би” буюу “өөрийгөө ухаарагчай” гэдэг ойлголтын үндэс болсон төдийгүй эдгээр философи үзэл нь **холистик шинжтэйг** илэрхийлж байна.
2. Нэгэнт *Natura Naturata*, *Natura Naturans* нь цор ганц субстанц буюу эзэн тэнгэрийг хоёр талаас тайлбарласан үзэл болохын хувьд энэ үүднээсээ аливаа юмс үзэгдлийг тасралтгүй үргэлжлэх шалтгаант харилцаанд авч үзсэн нь байгалийн хуулийн тухай **натуралист** санааг илэрхийлж байна.
3. Зорилго гэдэг ойлголт субстанцад хамаарахгүй ч түүний модусуудад илэрч байгаа нь гүн экологийг дэмжигч философичдын бүх юм өөрийн үнэлэмжтэй төдийгүй тэрхүү үнэлэмж, дотоод үнэ цэнэ нь өөрийн зорилготой гэж үзэх санаатай давхцаж байгаа нь **teleology** утгатай байна.

ABSTRACT

In this article, authors elucidate how pantheistic view of Spinoza who is the one of influential philosophers of XVII century has transformed into environmental approach as a holistic view in the XX century environmental philosophy. At our present time, climate change, global warming and especially human intervention to the earth become catastrophic in every field. Thus, we need more or another vision to living style, earth and intellectual change. Though, Spinoza's philosophical view has been discussed through many scholars, interconnectedness of environmental and philosophical questions still open to intellectual world.

НОМ ЗҮЙ

1. J.Baird Callicott and Robert Frodeman. Encyclopedia of Environmental Ethics and Philosophy USA. 2009.
2. Benedict Spinoza. Ethics Demonstrated in Geometrical Order. Jonathan Bennet. 2017.
3. Beth Lord. Spinoza's ethics. An Edinburgh Philosophical Guide. Edinburgh University Press Ltd. 2010.
4. F.C.Copleston. A History of Philosophy. Vol 4. Doubleday, USA. 1993.
5. <http://trumpeter.athabascau.ca/index.php/trumpet/article/view/1224>
6. https://www.researchgate.net/publication/305702378_Environmental_Philosophy
7. http://www.sophia-project.org/uploads/1/3/9/5/13955288/weber_spinoza.pdf